



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 56

Номгон

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын Тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 2017 онд сахилгын шийтгэл ногдуулсан 11 ажилтанд тус бүр 270.0 мянга, нийт 2970,0 мянган төгрөгийг олгосон.

2. Аж ахуйн нэгжээс өгсөн хандив болон бусад орлогын 30522.5 мянган төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлэлгүй сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, 27034.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно...”, 60 дугаар зүйлийн 60.2.5 дахь “Орон нутгийн хөгжлийн сан нь ... тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж... эх үүсвэр бүрдэнэ” гэсэн заалтууд болон Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох,

2517142

албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр орох орлогыг эрх зүйн хувьд журамлаагүй, төлөвлөгөөг батлаагүй байхад тухайн сан, хөтөлбөрт оруулсан орлого, бүрдүүлсэн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх", 3.1.7-д заасан"... төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хууль, тогтоомж зөрчиж олгосон 2,970,000 /Хоёр сая есөн зуун далан мянган/ төгрөгийг хавсралтад заасан ажилтнуудаар төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Аж ахуйн нэгжүүдээс өгсөн хандив болон бусад орлогын үлдэгдэл 3,488,000 /Гурван сая дөрвөн зуун наян найман мянган/ төгрөгийг сумын ОНХС-д төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

3. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2018 оны 04 дүгээр сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Галуут сумын Засаг даргын тамгын газрын дарга Т.Алтантуяа, нягтлан бодогч Х.Пүрэвнанзад нарт хариуцуулав.



АКТ

ЗӨВШӨӨРСӨН:

ТӨСВИЙН ЗАХИРАГЧ


Т.АЛТАНТУЯА

НЯГТЛАН БОДОГЧ

Х.ПҮРЭВНАНЗАД

1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
2018.02.24-ний өдрийн 26 тоот актын хавсралт

№	Ажилтны нэр	Сахилгын шийтгэл ногдуулсан тушаалын огноо, дугаар	Олгосон урамшууллын дүн	Суутгасан суутгал	Гарт олгосон урамшууллын дүн
1	Т.Алтантуяа	2017.05.30 №64	300,000	30,000	270,000
2	Г.Цэен-Ойдов	2017.08.25 №Б/86	300,000	30,000	270,000
3	Б.Мөнхжаргал	2017.08.25 №Б/86	300,000	30,000	270,000
4	Ж.Баярсайхан	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
5	Б.Анхбаяр	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
6	С.Ариунжаргал	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
7	Б.Батчимэг	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
8	Ж.Ганчулуун	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
9	Д.Ганзориг	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
10	А.Түмэннаст	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
11	Х.Пүрэвнанзад	2017.04.28 №24	300,000	30,000	270,000
ДҮН			3,300,000	330,000	2,970,000



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 61

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

"Их богдын наран" ХХК-аас нэг бүр нь 53.6 мянган төгрөгийн үнэ бүхий 100 ширхэг сандлын үнэнд 5360.0 мянган төгрөгийг нэхэмжилсэн баримтыг үндэслэн 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдөр тус компанид 4445.9 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч нэр данс зөрүүтэй тул буцаагдсан байна. Нэр данс зөрүүтэй тул залруулж шилжүүлэг хийхдээ Өлзий арвижих тавилгын үйлдвэрийн нэг бүр нь 74.0 мянган төгрөгийн үнэ бүхий 60 ширхэг сандлын үнэнд 4440.0 мянган төгрөг нэхэмжилсэн нэхэмжлэлээр, "Тулгабаян-Өргөө" ХХК-д 4445.9 мянган төгрөгийг шилжүүлж, авлагаар тусгасан./ Өлзий арвижих тавилгын үйлдвэрийн ахлагч Ж.Өлзийбаттай 2018 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 4440,0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан/


Дээрх нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно ...", 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэснийг зөрчсөн байна.

2518001


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Анхан шатны баримтгүй олгосон 4445,9 мянган төгрөгийг “Тулгабаян-Өргөө” ХХК-аар төлүүлж, Эрдэнэцогт сумын Соёлын төвийн 100030335090 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.04.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Соёлын төвийн төсвийн захирагч Л.Ганчимэг, нягтлан бодогч Ү.Банзрагч нарт хариуцуулав.

ТОГТООСОН:
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА
6417143544
Б40А0067 9007423

АКТ

ЗӨВШӨӨРСӨН:
ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Л.ГАНЧИМЭГ
НЯГТЛАН БОДОГЧ
Ү.БАНЗРАГЧ


1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2018 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 67

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ИТХ-ын 2017 оны 03 дугаар улирлын болон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. Багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарын 7.8-р сарын урамшууллаас хувь хүний орлогын албан татварыг тооцохдоо хуулийн дагуу 63.0 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийг чөлөөлөөгүй.

2. 2017 оны 12 дугаар сард хийсэн завсарын аудитаар 2017 оны 05 дугаар сард ажилтан Б.Отгонсүрэнд 190.0 мянган төгрөгийн урьдчилгааг олгож, суутгаагүй атлаа түүнийг авлагаар тусгаагүй.

3. Засварын аудитаар оны эхний авлагын 24.9 мянган төгрөгийн авлагыг барагдаагүй байхад хаалтын бичилт хийсэн алдаа илэрч, авлагын эзэн холбогдогчийг тогтоож, авлагыг барагдуулах зөвлөмж өгсөн байхад хэрэгжүүлээгүй.

Дээрх нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх "Энэ хуулийн ... заасан орлогод ногдох жилийн албан татварт 84000 төгрөгийн албан татварын хөнгөлөлт үзүүлнэ" гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх

2518015


...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь “Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон”, 3.1.7 дахь “Улсад болон байгууллагад хохирол учруулсан төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өмнөх оны 24,970 төгрөгийн авлагыг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар, цалингийн урьдчилгааны 190,000 төгрөгийг Б.Отгонсүрэнгээр төлүүлж, Төрийн сан дахь бусад татвар хураамжийн орлогын 100030000947 тоот дансанд төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. Багийн иргэдийн нийтийн хурлын дарга нарт 63,000 төгрөгийн татварын хөнгөлөлтийг буцаан олгох.

3. Төлбөрийн актыг барагдуулсан тухай баримтыг 2018.05.20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын ИТХ-ын төсвийн захирагч Б.Мөнхзул, нягтлан бодогч Б.Үлэмжсонин нарт хариуцуулав.

АКТ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.